



СТЕП ГОЛД ЛИМИТЕД

САНАЛ ӨГӨХ БОДЛОГО

Степ Голд Лимитед (цаашид “Степ” эсхүл “Компани” гэх)-ын захирлуудын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь захирал тус бүр нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн итгэлийг хүлээж, дэмжлэгийг авах ёстой гэж үздэг. Энэ зорилгоор, Зөвлөл нь энэхүү бодлогыг (цаашид “Бодлого” гэх) санал нэгтгэйгээр батлан гаргасан. Энэ Бодлого нь Компанийн одоогийн болон ирээдүйн бүх захирлуудад хамаарна.

1. Хурлын үеэр санал өгөх журам

1.1 Хувь хүн санал өгөх

Хувьцаа эзэмшигчдийн хурлууд дээр захирлуудыг сонгохтой холбоотой хувьцаа эзэмшигч нарт өгсөн итгэмжлэлийн маягтууд нь нэр дэвшигч бүрийг тусад нь дэмжихэд хувьцаагаа санал болгох эсхүл санал өгөхөөс татгалзах боломжийг хувьцаа эзэмшигч бүрт олгоно. Зөвлөлийн дарга нь захиралд нэр дэвших этгээд бүрийг дэмжихэд хувьцаагаа санал болгосон эсхүл санал өгөхөөс татгалзсан хувьцааны тоо ширхэгийг бүртгүүлэн, тухайн хурлын дараа нийтэд нэн даруй мэдээнэ. Хэрвээ саналыг гар өргөж хураавал, Компани нь захирал тус бүрийг дэмжин итгэмжлэлээр санал өгсөн эсхүл татгалзсан хувьцааны тоо ширхэгийг дэлгэн мэдээнэ.

1.2 Санал өгөхөөс татгалзах

Хэрвээ, Компанийн захирлуудын маргаангүй сонгуулиар, захиралд нэр дэвших аливаа тодорхой нэр дэвшигч нь тухайн нэр дэвшигчийг дэмжсэн саналын тооноос илүү их татгалзсан саналын тоо хүлээн авсан бол, компанийн хуулийн дагуу зохих ёсоор сонгогдсон хэдий ч, энэхүү Бодлогын зорилгоор, тухайн нэр дэвшигчийг хувьцаа эзэмшигч нарын дэмжлэгийг аваагүй гэж тооцох бөгөөд уг нэр дэвшигч тухайн хурлын дараа Зөвлөлийн даргад өөрийн огцрох өргөдлийг нэн даруй өгнө. Энэ Бодлогод, “маргаангүй сонгууль” гэдэг нь захиралд нэр дэвшигчийн тоо нь Зөвлөлөөс тогтоон сонгогдох захирлуудын тоотой тэнцүү байх сонгуулийг хэлнэ.

2. Хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг аваагүй нэр дэвшигч

2.1 Захирал огцрох өргөдөл өгөх

Энэхүү Бодлогын дагуу хувьцаа эзэмшигч нарын дэмжлэгийг аваагүй гэж тооцогдох захиралд нэр дэвшигч нь Зөвлөл хүлээн авснаар хүчин төгөлдөр болох өөрийн огцрох өргөдлийг Зөвлөлд нэн даруй өгнө. Зөвлөл нь тухайн өргөдлийг Компанийн засаглал болон нэр дэвшүүлэх хороонд (цаашид “Хороо” гэх) танилцуулна.

Хороо нь уг огцрох өргөдлийг анхааран авч хэлэлцээд, хүлээн зөвшөөрөх эсэх талаар Зөвлөлд зөвлөмж гаргана. Хороогоор хэлэлцэх үед, хувьцаа эзэмшигчид холбогдох захирлыг яагаад сонгохоос “татгалзсан” талаар мэдэгдсэн аливаа шалтгаан, албан тушаалын үргэлжлэх хугацаа, захирлын мэргэшил, чадвар, Компанид оруулсан хувь нэмрийг анхааран

судалж болох бөгөөд аливаа холбогдох засаглалын дүрэм, бодлого, Зөвлөлийн чиглэл, болон Хорооны гишүүдийн зүгээс чухал хамааралтай гэж үзэх аливаа бусад хүчин зүйлд нийцүүлэх Компанийн чадвар, эрх мэдлийн дагуу тухайн албан тушаалыг татгалзаж болно.

Зөвлөл 90 хоногийн хугацаанд огцрох өргөдлийг хэлэлцэхээр төлөвлөнө.

Зөвлөл нь огцрох өргөдөл өгсөн Захирлыг сонгосон хурлын дараах 90 хоногийн хугацаанд Хорооны зөвлөмжийг анхааран авч үзнэ. Хорооны зөвлөмжийг хэлэлцэхдээ, Зөвлөл нь хорооноос анхааран авч үзсэн хүчин зүйлс болон Зөвлөлийн зүгээс чухал хамааралтай гэж үзэх нэмэлт мэдээлэл, хүчин зүйлсийг анхааран судална. Огцрох өргөдөл нь Зөвлөл хүлээн зөвшөөрснөөр хүчинтэй болно.

2.2 Огцрох өргөдлийг хэлэлцэх үед гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаа

Энэ Бодлогын дагуу өөрийн огцрох өргөдлийг өгөх аливаа захирал нь тухайн өгсөн өргөдлийг хүлээн авах эсэх талаарх Зөвлөл эсхүл Хорооны хэлэлцүүлэгт оролцохгүй. Гэвч, уг захирал нь энэ Бодлогын дагуу тодорхойлсон үйл явцын үеэр хорооны болон Зөвлөлийн бүх бусад үйл ажиллагаа, хэлэлцүүлэг, шийдвэрүүдэд оролцон, ажлаа хэвээр үргэлжлүүлнэ.

2.3 Хэвлэлийн мэдэгдэл

Огцрох өргөдлийн талаарх Зөвлөлийн шийдвэрийн дараа, Зөвлөл нь тухайн Захирлын огцрох өргөдлийг хүлээн зөвшөөрсөн эсэх тухай шийдвэрийг хэвлэл мэдээллээр нэн даруй зарлана. Хэрвээ Зөвлөл огцрох өргөдлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, өөрийн шийдвэрийн шалтгааныг уг хэвлэлийн мэдэгдэлд оруулна. Хэвлэлийн мэдэгдэлийн хуулбарыг TSX-д өгнө.

3. Сул орон тоо гарах

3.1 Зөвлөлийн сонголтууд

Зөвлөл нэг эсхүл түүнээс их огцрох өргөдлийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд, болон компанийн хуулийн дагуу тавигдах хязгаарлалт эсхүл шаардлагад нийцүүлэн, Зөвлөл нь:

- (a) Дараагийн жилийн ерөнхий хурал хүртэл тухайн сул орон тоог хэвээр үлдээж болно;
- (b) Зөвлөлийн зүгээс Хувьцаа эзэмшигчдийн итгэлийг хүлээж чадна гэж үзсэн шинэ захирлыг томилон тухайн сул орон тоонд ажиллуулна; эсхүл
- (c) Хувьцаа эзэмшигчдийн тусгай хурлыг зарлан хуралдуулж, тухайн сул орон тоо эсхүл албан тушаалд нэг эсхүл түүнээс их удирдлагын нэр дэвшигчийг танилцуулна.

4. Ерөнхий

Энэ бол бодлого бөгөөд тодорхой хугацаанд Зөвлөлийн зүгээс өөрчилнө. Түүнчлэн, тодорхой хугацаанд, Зөвлөл нь үүнтэй холбоотой нөхцөлүүдийг ирээдүйд эсхүл өнгөрсөн үед өөрчлөхийг зөвшөөрч болно. Энд заасан нөхцөл нь Компанийн хувьцаа эзэмшигчдэд иргэний үүрэг хариуцлага эсхүл аливаа бусад хариуцлага хүлээлгэхгүй болно.

Баталсан огноо: 2017 оны 10-р сарын 2

Зөвшөөрсөн: Компанийн засаглал болон нэр дэвшүүлэх хороо

Захирлын Зөвлөл